



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/642

Мөрөн сум

Барилга байгууламж ашиглалтад оруулах  
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Улаан-Уул суманд баригдсан Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлыг хүлээн авч ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Энхжаргал	(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)
Гишүүд:	Б.Анхбаяр	(Боловсролын ерөнхий газрын хяналтын инженер)
	Д.Тулга	(Барилгын хөгжлийн төвийн ББЗХХэлтсийн хяналтын инженер)
	Г.Батхүү	(Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын хөрөнгө оруулалт гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэн)
	Х.Даваасүрэн	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)
	Д.Мягмарсүрэн	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)
	Ж.Жавзанпагма	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)
	С.Анхбаяр	(Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад)
	Д.Аюушжав	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

6712011537



2.

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

А.Ганхуяг ("Стийл проект" ХХК-ийн инженер)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Д.Ганзориг ("Зоос импекс" ХХК-ийн менежер)

Т.Бат-Орших ("Зоос импекс" ХХК-ийн инженер)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Д.Бүрэнчөдөр (Улаан-Уул сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга)

Н.Батбаяр (Улаан-Уул сумын Засаг дарга)

П.Баттуяа (Улаан-Уул сумын сургуулийн захирал)

Э.Энхцэцэг (Улаан-Уул сумын сургуулийн нягтлан бодогч)

Э.Баярмагнай (Улаан-Уул сумын сургуулийн нярав)

Д.Нарантуяа (Улаан-Уул сумын сургуулийн ХАБЭА-н ажилтан)

Комиссын нарийн бичгийн дарга:

Д.Нямбат (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Барилга байгууламжийг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилга байгууламжийг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Д.Нямбат) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

